



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 49 (186)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- Улс төрийн хилс хэрэгт хэлтэгдэгчдийг цагаатгах,  
тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт  
оруулах тухай

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- Засгийн газрын үйл ажиллагааны тэрхүүлэх  
чиглэлийг батлах тухай

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот  
2000 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2000 оны арванхоёрдугаар сарын 27 №49 (186)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

521. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

(2000-12-8-ны хууль) 846

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

522. Монгол Улсын 2001 оны төвлөрөн төсвийн хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Дугаар 52 846

523. Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Дугаар 53 846

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

524. Дүгэржавын Дулмаад Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртэлх тухай

Дугаар 168 847

525. Хүнсний аж үйлдвэрийн салбарын зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Дугаар 169 847

526. Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Дугаар 170 848

527. Зарим шүүхийн шүүгчийг томилох тухай

Дугаар 171 848

### Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

528. Төрийн өмчт үйлдвэрийн газар байгуулах тухай

Дугаар 159 849

529. Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг батлах тухай

Дугаар 161 851

530. Үндэсний хорооны бүрэлдэхүүний шинэчлэн батлах тухай

Дугаар 163 852

531. Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн тухай

Дугаар 164 852

532. Зөвлөлийн бүрэлдэхүүн батлах, дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Дугаар 166 861

533. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Дугаар 168 861

534. Аялал жуулчлалын улсын хяналтын дүрэм батлах тухай

Дугаар 169 862

535. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүний тухай

Дугаар 170 864

### Үншигчдийн анхааралд

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2000 оны арванхоёрдугаар сарын 05-ны едрийн №45-д нийтгэдсэн Монгол Улсын Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2000 оны 11 дүгээр сарын 16-ны едрийн хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт байгаа Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дахь хэсгийн 1 дахь залвартад "аж ахуйн нэгж, байгууллагын" гасний дараа "таслал (.)" байх ёстой байтал манай ажилтны буруугаар таслалгүйгээр алдаатай хэвлэсэн байх тул хуулийн уг залвартыг дараах байдлаар запруулж хэрэглэхийг мэдэгдье:

"1/ тухайн төсвийн жилд улсын төвлөрөн төсөвтэй харьцахаар тогтоосон болон нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын, импортын барааны, мөн алтны борлуулалтад ногдох нэмэгдсэн өртгийн албан татвар"

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 12 дугаар  
сарын 8-ны өдөр

Улаанбаатар  
 хот

**УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ  
ЦАГААТГАХАА, ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ  
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 6.3-ын "З жилийн дотор" гэсний "5 жилийн дотор"; 12.3-ын "энэ хууль хувчин төгөлдөр болсноос хойш 3 жил" гэсний "2003 оны 2 дугаар

сарын 1-ний дотор" гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Л.ЭНЭБИШ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 12 дугаар  
сарын 8-ны өдөр

Дугаар 52

Улаанбаатар  
 хот

**Монгол Улсын 2001 оны төвлөрсөн  
төсвийн хуулийг хэрэгжүүлэх арга  
хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:  
1. Монгол Улсын 2001 оны төвлөрсөн төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар / Н.Энхбагрын тогтолцоогүй:

1/татвар ногдуулалт, хуваалтыг эрэс сайжруулан татварын орлогыг бүрэн төвлөрүүлэх, дадл эдийн засгийн илрүүлэх бизнес, эрх зүйн орчны бүрдүүлэх, татвар хуваалтад төрийн захиргаанд хяналт тавих байгууллагыг бий болгох чиглэлээр татварын албыг бэхжүүлэх асуудлыг яаралтай боловсруулж шийдвэрлүүлэх;

2/төсвийн орлого, нийгмийн даатгалын шимтгэлийн хураамжийг хуулийн дагуу бүрэн төвлөрүүлж төсвийн байгууллагуудын цалин, санхүүжилт, тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд нь олгох хэвшиүүлэх;

3/терийн нэрийн өмнөес үйл ажиллагааг явуулж орлогоороо санхүүжиж байгаа төрийн захиргааны байгууллагуудын жилийн төсвийг батлан өгч, төсвийн давсан орлогыг нь төвлөрүүлж батлагдсан хэмжээгээр нь санхүүжүүлэх;

4/төсвийн байгууллагуудад ууссан өр авлагыг судлан шийдвэрлэж, дахин өр үүсэхгүй байх нөхцөл бүрдүүлэх;

5/улс, орон нутгийн төсвийн эрх

захирагчдад тавих шаардлагыг чангатган төсвийг зориулалт бусаар зарцуулсан тохиолдолд тэднийг уг ажилдаа тэнцэж байгаа эсэхийт заавал авч хэлэлцэх шийдвэр гаргадаг болох, орлогын эх үүсвэр олж нэмэгдүүлэсэн, зардал хэмнэсэн тохиолдолд урамшууллах механизмыг тогтоох;

6/төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих санхүүгийн хяналт, сахилгыг бүх шатанд хүчтэй болгох;

7/улс орны нийгэм, эдийн засаг, төсвийн нөхцөл байдлын талаар олон нийтэд бодитийоор ойлгуулах, сурталчлах ажлыг тогтмол хийж байх.

2. Төсвийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын шинэчлэлтийг төсвийн байгууллагын удирдлагыг, санхүүжилтийн шинэ тогтолцоог туршин нэвтрүүлэх ажилтай няйт уялдуулан зохион байгуулж, зардал хэмнэлтийн хатуу горим мөрдүүлэх;

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавиж ажиллахыг Төсвийн байнгын хороо /Н.Баяртайхан/-д үүргэ болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Л.ЭНЭБИШ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 12 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар 53

Улаанбаатар  
 хот

**Байнгын хорооны бүрэлдэхүүнд  
өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүн Л.Гундалайн хүснэгтийг харгалzan түүнийг Байгаль орчин,

хөдөөгийн хөгжлийн Байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Эдийн засгийн байнгын хорооны гишүүнээр баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Л.ЭНЭБИШ



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 12 дугаар  
сарын 07-ны өдөр

Дугаар 168

Улаанбаатар  
хот

Дүгээржавын Дулмаад Монгол Улсын аж  
үйлдвэрийн гавьяат ажилтан цол  
хүртээх тухай

Хүнсний аж үйлдвэрийн салбарт олон жил  
үр бүтээлтэй ажиллаж бутэгдэхүүний нэр төрлийг  
опшруулах, чанарыг дээшшуулэх, үйлдвэрлэлийг  
нэмэгдүүлэх, хүн амын хүнсний хангамжийг  
сайжруулахад болон залуу ажилчдыг сургаж  
дадлагахуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь  
үнэлж чихэр, боовны үйлдвэрлэлийн "Дээж стар"

ХХК-ийн ажилчин Дүгээржавын Дулмаад Монгол  
Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол  
хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

2000 оны 12 дугаар  
сарын 07-ны өдөр

Дугаар 169

Улаанбаатар  
хот

Хүнсний аж үйлдвэрийн салбарт олон жил  
үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан

хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

## ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

- |                            |   |
|----------------------------|---|
| 1. Гончигийн Гомбо         | - Техникийн их сургуулийн хүнсний технологийн сургуулийн захирал                    |
| 2. Дашийн Пүрэвжав         | - Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Талх чихэр" ХК-ийн ерөнхий менежер             |
| 3. Цэцэгзэгийн Хишигтогтох | - Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Өгөөж-Чихэр боов" ХХК-ийн засварчин            |
| 4. Лхагвын Янжин           | - Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Талх чихэр" ХК-ийн гоймонгийн үйлдвэрийн дарга |

## "АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

- |                                 |   |
|---------------------------------|---|
| 1. Лхасурэнгийн Авидсүрэн       | - Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Өгөөж-Чихэр боов" ХХК-ийн засварчин        |
| 2. Жижжавын Бавуу               | - Дархан-Уул аймгийн "Дархан хүнс" ХК-ийн менежер                               |
| 3. Гунгаагийн Бадрах            | - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Эрдэнэ хүнс трейд" ХК-ийн ерөнхий захирал |
| 4. Дагын Банзрагч               | - Дархан-Уул аймгийн "Дархан хүнс" ХК-ийн гүйцэтгэх захирал                     |
| 5. Бариширийн Галбадрах         | - Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Нийслэл Өргөө" ХК-ийн ажилчин              |
| 6. Темер-Очирын Жүгдэрмэа       | - Нийслэлийн "АПУ" ХК-ийн химич   |
| 7. Аюушийн Оттон                | - Улаанбаатар хотын Захирагчийн албаны мэргжилтэн                               |
| 8. Ламжавын Пагамдулам          | - Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний "Монсүү" ХК-ийн ерөнхий технологич        |
| 9. Даржаагийн Пүрвээ            | - Монголын цагаан идээ үйлдвэрлэгчдийн холбооны ерөнхий зөвлөх                  |
| 10. Мажигсурэнгийн Ренчинтогтох | - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Сүхбаатар хүнс" ХХК-ийн захирал           |
| 11. Довдонгийн Содномрэнцэн     | - Баянхонгор аймгийн Баянхонгор сумын "Түйн тас" ХХК-ийн захирал                |
| 12. Дэлгэдоогийн Цэцэгмаа       | - Баянхонгор аймгийн Баянхонгор сумын "Илч трейд" ХХК-ийн захирал               |
| 13. Гончигийн Чимэздорж         | - Нийслэлийн "Максимпекс" ХК-ийн ажилчин  |
| 14. Пүнцагайиin Юмжир           | - Баянхонгор аймгийн Баянхонгор сумын "Илч трейд" ХХК-ийн мастер                |
| 15. Навааншүхэрийн Ядамсүрэн    | - Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Талх чихэр" ХК-ийн инженерийн албаны дарга |



## ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Роломжавын Батбаяр  
2. Гундсамбуунийн Болд  
3. Жадамбаагийн Бямбасүрэн  
4. Пүрэвийн Гуржав  
5. Лувсандоржийн  
Дагийсүрэн  
6. Очирын Жанчидорж  
7. Чойжамцын Ичинхорлоо  
8. Нямцэрэнгийн Менхцэцг  
9. Мандахын Намчин  
10. Гээдэngийн Орлом  
11. Цэнджавын Оюончуулун  
12. Жамбалдоржийн  
Энерцэг  
13. Дагдангийн Сумьяа  
14. Пэлжээгийн Хандсүрэн  
15. Нацагдоржийн Чинтоогох
- Нийслэлийн "Махимпекс" ХК-ийн мастер  
- Нийслэлийн "АПУ" ХК-ийн мэргжилтэн  
- Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Өгөөж-Чихэр босс" ХХК-ийн жолсооч  
- Нийслэлийн "АПУ" ХК-ийн үйлчлэгч  
- Нийслэлийн "АПУ" ХК-ийн ажилчин  
- Нийслэлийн "Махимпекс" ХК-ийн ажилчин  
- Архангай аймгийн Эрдэнэбулаг сумын "Хүнс-Ар" ХК-ийн ажилчин  
- Дундговь аймгийн Сайнцагаан сумын "Говийн тэнгэр" ХХК-ийн ажилчин  
- Увс аймгийн Улаангом сумын "Хүнс-Увс" ХК-ийн ажилчин  
- Дархан-уул аймгийн "Дархан хүнс" ХК-ийн мастер  
- Нийслэлийн "Махимпекс" ХК-ийн ажилчин  
- Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Эрдэнэ хүнс трейд" ХХК-ийн технологи  
- Архангай аймгийн Эрдэнэбулаг сумын "Хүнс-Ар" ХК-ийн ажилчин  
- Дархан-Уул аймгийн "Дарханхүнс" ХК-ийн мастер  
- Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Турван-Од" ХХК-ийн мэргжилтэн

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 12 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 170

Улаанбаатар  
хотШүүгчийн албан тушаалаас чөлөөлөх  
тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай" хуулийн 51 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1,2 дахь заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Өөрөө хүслэлт гаргасан Дагвадоржийн Цолмонг Булган аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Чuluунбаатарын Энхтуяаг Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, өөр шатны шүүхэд шилжин ажиллах болсон тул Агаана

Сүгарсурэнг Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Тумагийн Цэцэгмааг Ховд аймаг дахь сум дундын 1-дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 12 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 171

Улаанбаатар  
хотЗарим шүүхийн шүүгчийг томилох  
тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2, "Шүүхийн тухай" хуулийн 6-дугаар зүйлийн 2,4 дэх хэсгийг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Тумагийн Цэцэгмааг Ховд аймгийн шүүхийн шүүгчийн; Агаанаы Сүгарсурэнг Дундговь аймгийн шүүхийн шүүгчийн, Чойдонгийн Дулмааг Увс аймгийн шүүхийн шүүгчийн, Гомбын Нямхуут

Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Бэзгийн Дамбыг Ховд аймаг дахь сум дундын 1-дугаар шүүхийн шүүгчийн, Нямжавын Туяаг Ховд аймаг дахь сум дундын 2-дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 10 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 159

Улаанбаатар  
хотТөрийн омчт үйлдвэрийн  
газар байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн омчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5-д засныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Даланзадгадын дулааны цахилгаан станц" төрийн омчт үйлдвэрийн газрыг байгуулсугай.

2. "Даланзадгадын дулааны цахилгаан

станц" төрийн омчт үйлдвэрийн газрын дурмийг хавсралт ёсоор баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
САЙД**

Н.ЭНХБАЯР

**ДЭД БҮТЦИЙН САЙД**

БЖИГЖИД

Засгийн газрын 2000 оны 159  
дүгээр тогтоолын хавсралт

**"ДАЛАНЗАДГАДЫН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ"  
ТӨРИЙН ОМЧТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

хангах арга хэмжээг зохион байгуулж шийдвэрлэх;

г/станцын ашиглалт, засвар үйлчилгээний түвшинг байнга дээшлүүлэх;

д/эрчим хүчиний хөгжлийн бодлогын хүрээнд хэрэгжих техникийн шинэчлэл, тэргүүний техник, технологийг нэвтрүүлэх;

е/эрчим хүчиний үйлдвэрлэл, дамжуулалт, хуваарилалт, хэрэглээнд хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх;

ж/тоног төхөөрөмжийн найдвартай, эдийн засгийн үр ашигтай ажиллагаанд хяналт тавьж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дурэм, техник ашиглалтын дурмийг мөрдөж ажиллах.

**Гурав. Станцын эрх**

6. Даланзадгадын дулааны цахилгаан станц нь үндсэн зорилгоо хэрэгжүүлэхдээ дараах эрхтэй байна:

а/эрчим хүчиний унэ, тарифыг тогтоох санал боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулах;

б/үйл ажиллагааныхаа чиглэлээр бие даан гадаад худалдаа эрхлэх, эрхэлсэн асуудлаараа гадаад орон, олон улсын болон мэргэжлийн байгууллагатай харилцааж тогтоосон журмын дагуу гэрээ байгуулах, мэдээлэл солилцох;

в/Засгийн газрын болон Засгийн газрын бус байгууллагатай гэрээ байгуулах;

Хоёр. Станцын үүрэг

5. Даланзадгадын дулааны цахилгаан станц нь үндсэн зорилгоо хэрэгжүүлэхээр дараах үйл ажиллагааг явуулна:

а/хэрэглэгчдийг эрчим хүчээр жигд, найдвартай хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

б/эрчим хүчиний салбарын бодлогыг тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, мэргжил, арга зүйн удирдлагаар хангах;

в/станцын мэргэжлийн ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, тэдний ажиллах нехцел, нийгмийн баталгааг



г/өөрт олгогдсон үл хедлэх хөрөнгийг энэхүү дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах;

д/“Төрийн болон орон нутгийн вимчийн тухай хууль”-д заасан эрх хэмжээний дотор үндсэн хөрөнгийг захиран зарцуулах;

е/өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор зохих журмын дагуу эзэл авч ашиглах;

ж/үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас эрх бүхий байгууллагаас баталсан нормативт хэмжээгээр өөртөө үлдээж захиран зарцуулах;

з/үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ өөрөө бие даан борлуулах.

#### Дерев. Станцын эд хөрөнгө

7. Станцын эд хөрөнгө нь үндсэн болон эргэлтийн хөрөнгө, санхүүгийн бусад неөвөөс бүрдэнэ.

8. Станцын хөрөнгийг бурдуулэх эх үүсвэр нь:

а/эзэл, төсвийн хөрөнгө;

б/хууль ёсоор олж авсан бусад хөрөнгө;

в/өөрийн үйл ажиллагаваны үр дүнд олсон ашгаас эрх бүхий байгууллагаас баталсан нормативт хэмжээгээр өөрт үлдэх ашиг.

9. Станцын эд хөрөнгийг “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ.

#### Тав. Удирдлага

10. Станцын даргыг Төрийн өмчийн хороо Дэд бүтцийн яамтай зөвшилцэн томилж, чөлөөлнө.

11. Станцын дарга нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааг шууд удирдлагаар хангаж, түүний зорилт, үүргийг хэрэгжүүлэх, үр ашигтай ажиллуулахаар Төрийн өмчийн хорооны даргатай үр дүнгийн гэрээ байгуулан ажиллана.

12. Станцын дарга нь станцын захиргааны бүтцэ, орон тоог тогтоон, ажиллагсдыг томилж, чөлөөлөх бөгөөд батлагдан цалингийн будууч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох, ажиллагсдад олгох буцалтгүй тусламжийн

хэмжээ, олгох нехцэл журмыг баталж мөрдүүлнэ.

13. Станцын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдолтой асуудлыг станцын дарга бие даван шийдвэрлэнэ. Станцын дарга хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас гаргасан эрх зүйн актад нийцүүлэн тушаал гаргана.

14. Зохих хуульд заасны дагуу даргын (захирлын) зөвлөл байгуулж ажиллуулж болно.

15. Станцын ерөнхий инженер, ерөнхий нягтлан бодогчийг станцын даргын саналыг үндэслэн Эрчим хүчиний удирдах газрын даргын тушаалаар томилж, чөлөөлнө.

#### Зургаа. Эдийн засгийн үйл ажиллагаа

16. Станцын эдийн засгийн үйл ажиллагаа нь жил бүрийн үйлдвэрлэл, түүний үр ашиг, орлогыг тодорхой тусгаж, зохих газруудаар баттуулсан бизнес төлөвлөгөөний дагуу явагдана.

17. Хууль тогтоомжийн дагуу орлогын болон бусад татвар, хураамжийг төлнө.

18. Эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу ногдол ашигийг төсөөт оруулна.

19. Зохих журмын дагуу тайлан тэнцлийг улирлаар гаргаж Төрийн өмчийн хороо, холбогдох татварын алба, санхүүгийн байгууллагад хүргүүлнэ.

20. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, хөдөлгөөнд бүртгэлээр тавих хяналтыг үйлдвэрлийн захиргаа хариуцна.

#### Долоо. Хариуцлага

21. Станцын удирдлага нь Монгол улсын хууль тогтоомж, энэхүү дүрмээр хүлээсэн үргээз биелүүлээгүй буюу зурсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хулээнэ.

#### Найм. Станцыг өөрчлөн байгуулах, татан буулагх

22. Станцыг холбогдох яам болон Төрийн өмчийн хорооны санал болгосноор Засгийн газар өөрчлөн байгуулж, татан буулагна. Станцын зохих журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 10 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 161

Улаанбаатар  
хот

**Засгийн газрын үйл  
ажиллагааны тэргүүлэх чиглэлийг  
батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын 2000 оны 33 дугаар тогтооолоор баталсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зорчимжуулэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг хавсралт ёсоор баталсугай.

2. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг хангахтай холбогдсон удирдлага, зохион байгуулалтын бүх төрлийн арга хэмжээг Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг

хэрэгжүүлэх ажилтай нягт уялдуулан зохион байгуулахын хамт энэхүү үйл ажиллагаанд төрийн захиргааны төв болон орон нутгийн бүх шатны байгууллага, түүнчлэн төрийн бус, хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний байгууллага, иргэдийг татан оролцуулах чиглэлээр ажиллахыг сайд, бүх шатны Засаг дарга наарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
САЙД**

Н.ЭНХБАЯР

**ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ө.ЭНХТҮҮВШИН

Засгийн газрын 2000 оны 161  
дүгээр тогтооолын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ**

1. Макро здийн засгийн тогтвортойлтыг ханган шинэчлэлийг гүнзгийрүүлж, бүтцийн өөрчлөлтийг зорчимжуулэх

2. Банк, санхүүгийн тогтолцоог эрүүлжүүлэх

3. Үндэсний үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжих замаар здийн засгийн ёсөлтийг хангах

4. Бүс нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг тулхуу хөгжүүлэх

5. Хүний хөгжлийг хангах тэгш орчин бүрдүүлж, бүх шатны боловсролын чанар, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх.

6. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, ард иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх

7. Тогтвортой хөгжил, экологийн тэнцвэрт байдлыг хангах байгаль орчны бодлогыг бус

нутгийн нийгэм-здийн засгийн хөгжлийн чиглэлтэй уялдуулан хэрэгжүүлэх.

8. Газрын шинэтгэлийг зорчимжуулэх

9. Томоохон хот, суурин газруудын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлыг дахин боловсруулах замаар иргэдийн амьдралх орчныг сайжруулах

10. Засаглалын хямралыг арилгаж, хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглалыг бүрдүүлэх

11. Шүүх засаглалын хараат бус бие даасан байдал, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах замаар иргэн бүрийн үндсэн эрх, эрх чөлөө, ардчиллын тулгуур зарчмыг баталгаатай хамгаалсан ёндер ёс суртахуун бүхий иргэний ардчилсан нийгмийг төлөвшүүлэх.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 10 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 163

Улаанбаатар  
хот

НҮБ-ын Ерөнхий Ассамблей, Дэлхийн цаг уурын байгууллагын зөвлөмж, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцийн хүрээнд хүлээсэн үүргээ билүүлэх, түүний хэрэгжилтийн түвшинг үндэсний хүрээнд хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Уур амьсгалын Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг дор дурдсанаар шинэчлэн баталсугай:

Дарга	-Байгаль орчны сайд.
Дэд дарга	-Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд.
Гишүүд:	-Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; -Санхүү, здийн засгийн яамны Эдийн засгийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;
	-Гадавад хэргийн яамны Олон талт хамтын ажиллагааны газрын дарга;
	-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Стратегийн төлөвлөлтийн бодлогын газрын дарга;

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 10 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 164

Улаанбаатар  
хот

Батлан хамгаалах яамны ўйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Батлан хамгаалах яамны ўйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг хөвсргэлтэй ёсоор зөвшөөрсүгэй.
2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Батлан хамгаалах яамны ўйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг батлах

тухай" Засгийн газрын 1997 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 141 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
САЙД

Н.ЭНХБАЯР

БАТЛАН ХАМГААЛАХЫН  
САЙД

Ж.ГҮРРАГЧАА

Засгийн газрын 2000 оны 164 дүгээр  
тогтооолын хөвсргэлт

**БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ЙҮЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ,  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР**

1.0. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Батлан хамгаалах яамны ўйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /цаашид

1.1. Оршил



"хөтөлбөр" гээнэ/т Батлан хамгаалахын сайдын болон Засгийн газрын Танхимын шийдвэрлиг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, төрийн захиргваны удирдлага, зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үр дунд нь үнэлгээ өгөх асуудлыг хамарсан Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлов.

#### 1.2. Үндэслэл

Хөтөлбөрийг Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтооолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг, Засгийн газрын 1996 оны 205 дугаар тогтооолоор зөвшөөрсөн "Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр", Засгийн газрын Удирдлагын хөгжлийн хөтөлбөрийн "Төрийн захирага, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл" бүрэлдэхүүн хэсгийн МОН/94/102 төслийн хүрээнд боловсруулан "Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн ерөнхий загвар" төслийн тайлант тус тус үндэслэн боловсруулав.

#### 1.3. Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

-Монгол Улсын Үндсэн хууль;

-Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;

-Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль;

-Монгол Улсын Хилийн тухай хууль

-Монгол Улсын Иргэний хамгаалалтын тухай хууль;

-Монгол Улсын Засаг захирага, нутаг

дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;

-Монгол Улсын Төрийн албаны тухай хууль;

-Төрийн цэргийн бодлогын үндэс;

-Бусад хууль тогтоомж.

#### 1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад олон улсын туршлага, өөрчлөлтийн удирдлага, үйл ажиллагаа /бизнес/-ны төлөвлөлт болон дахин инженерчлэл, байгууллагын өөрчлөлтийн зэрэг арга зүйг хэрэглэв.

1.5. Чиглэлийн яамны үүрэг хариуцлагын ерөнхий хуваары

Чиглэлийн яамдын нэг болох Батлан хамгаалах яам нь Засгийн газрын үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх талаар үүрэг хариуцлага хүлээж, Батлан хамгаалахын сайд, Засгийн газрын Танхимд бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ.

Батлан хамгаалах яам нь стратегийн бодлого, төлөвлөлт болон салбарын төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоо хангах асуудалд Засгийн газар, яамны өндөрлөгөөс өргөн хүрээтэй хандаж, зөв зохицтой удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ.


Засгийн газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий чиглэлийн яамдын нэг болох Батлан хамгаалах яам нь Засгийн газрын батлан хамгаалахын зөвлөхийн үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Батлан хамгаалах яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг зөв тодорхойлох нь тус яамны үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой юм. Энэ хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана.



**БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ СТРАТЕГИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР**





Батлан хамгаалах яамны ундын үйлчилүүлэгч буюу хэрэглэгч нь Батлан хамгаалахын сайд, Засгийн газрын Танхим байна.

Батлан хамгаалах яамны стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, ялангуяа ундын үйлчилүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтой холбогдоно уссаан олон төрлийн нарийн түвшгээний харилцагаа зохицуулахад чиглэнэ.

Батлан хамгаалах яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрэс, төрөл, хэлбэрийн хэрэгцээний эх үүсвэр тус бүрэр тогтоон тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэжүүдийн зорилт, чиг үүргээ, төрийн албан хаагчдын ажлын байр/албан тушаал/-ны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

## 2.0. БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

### 2.1. Үйл ажиллагааны стратегийн мончанар

Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратегийн мончанар нь Засгийн газрын үйл ажиллагааны тэргуулэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлжад чиглэсэн Батлан хамгаалахын сайдын үйл ажиллагаанд өндөр мэргэшлүүн, цаг үеэ опсон, шуурхай зөвлөгөө, бухтальны дэмжэлгээ үзүүлэхэд оршино.

### 2.2. Үйл ажиллагааны тэргуулэх чиглэл

Батлан хамгаалах яам нь дор дурдсан үйл ажиллагааны тэргуулэх чиглэлтэй ажиллана:

1. Батлан хамгаалах яамыг стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөржүүлэх, зохицуулах, хяналт-шинжилгээ хийх, үнэлгээг авах чиг үүргээгэй төрийн захиргааны төв байгууллага болгох замаар үйл ажиллагааны нь үр нөөө, үр ашигийг эрс дээшүүлэх;

2. Эдийн засгийн зах зээлийн харилцааны онцлогтой нийцүүлэн орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах тогтолцооны эрх зүйн үндсийг бүрдүүлэх;

3. Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэжүүдийн үйл ажиллагааг улс орны аюулгүй байдал, батлан хамгаалах эрх ашигт нийдүүлэн төреөс зохицуулах хууль, эрх зүйн үндсийг бий болгох;

4. Зэвсэгт хүчиний бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн, тайван цагийн бүтэц, бүрэлдэхүүнээрээ байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэх чадвар бүхий анги, салбаруудыг байгуулах;

### 2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго

**Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны эрхэм зорилго**

Зэвсэгт хүчиний мэргэжлийн чиг баримжийтэй, чадварын болгох, батлан хамгаалах улс төв, эзбий засах, нийдээ, эрг зүй, эзрэгийн измээдээ тохиолдсог бүрдүүлэхийн умсган дээр ус орнигтоо тусгавар тохиолын, нутгийн зэвсэгийн бүрэн бүтэн байдлын наёдворчийт хангах.

2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт  
Батлан хамгаалах яам нь эрхэм зорилтуулж хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

1. Батлан хамгаалах үйл ажиллагааны стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжаар хангах;

2. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;

3. Батлан хамгаалах салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах;

4. Батлан хамгаалах үйл ажиллагааны стратегийн төлөвлөгөө, бодлогын хэрэгжилтийг хяналт-шинжилгээ / мониторинг/ хийх, үр дунд нь үнэлгээг авах.

### 2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратегийн зорилт бурийн хүрээнд тэдээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг дэвшүүлэн ажиллана:

1.0. Үйл ажиллагааны стратегийн нэгдүгээр зорилтын хүрээнд:

1.1. Улс орны батлан хамгаалах урт, дунд, болгоно хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, батлан хамгаалах салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, тесэл боловсруулах;

1.2. Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөлөө, төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны даалгаврыг боловсруулах, тодотгох;

1.3. Гадаад орнуудтай цэргийн итгэлцлийг бэзжүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагааг өргөтгэн хөгжүүлэхэд мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээгээр хангах.

2.0. Үйл ажиллагааны хөрдүгээр зорилтын хүрээнд:

2.1. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлын манлайллыг хангах;

2.2. Батлан хамгаалах бодлогыг сурталчлах, хэрэглэгчдэд соёл, мэдээлээр үйлчилэх, олон нийттэй харьцах.

3.0. Үйл ажиллагааны стратегийн төрөвлөгөө зорилтын хүрээнд:

3.1. Бодлого, төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн зохицуулах;

3.2. Батлан хамгаалах төсвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах.

4.0. Үйл ажиллагааны стратегийн төрөвлөгөө зорилтын хүрээнд:

4.1. Батлан хамгаалах бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, тесэл, хамтын ажиллагааны гэрээ, халзангаарийн хэрэгжилтийг хяналт-шинжилгээ / мониторинг/ хийх, үр дунд нь үнэлгээг авах;

4.2. Батлан хамгаалах салбарын мэдээллийн сан, дотоод сүлжээ байгуулах.

2.6. Үйл ажиллагааны зорилт

Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны гол зорилт тус бурийн хүрээнд тэдээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны



зорилтыг тус яам тодорхойлж хэрэгжүүлна.

#### 2.7.Үйл ажиллагааны стратегийн загварт

Батлан хамгаалах яамны үйл ажиллагаа /

бизнес-/ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:

Эрхэм зорилго

Үйл ажиллагааны стратегийн зорилт

Үйл ажиллагааны гол зорилт

Үйл ажиллагааны зорилт

**Зэвсэгт хүчиний мэргэжлийн чиг баримжаатай чадварлаг болгох, батлан хамгаалах улс төр, эдийн засаг, нийгэм эрх зүй, цэргийн нэгдмэл тогтолцоог бүрдүүлсний үндсэн дээр улс орныхоо тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг найдвартай хангах**

1. Батлан хамгаалах үйл ажиллагааны стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжвар хангах

2. Төрийн захиргааны удирдлагын мянгуйллыг хангах

3. Батлан хамгаалах салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах

4. Батлан хамгаалах үйл ажиллагааны стратегийн төлөвлөгөө, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дунд нь үнэлгээ өгөх

1.1.Улс орны батлан хамгаалах урт, дунд, болино хувацааны стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжкар хангах, цэргийн шинжүүх үхдан технологийн бодлого, хотелбер, тесэл боловсруулах

1.2.Улсын дайчилгээны нэгдсэн төлөвлөгөө, төрийн захиргааны төв байгууллага, зйамаг, нийслэлийн дайчилгээны даалгаврыг боловсруулах, тодотох

1.3.Цэргийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөтөн хөгжүүлах, мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээгээр хангах.

2.1.Төрийн захиргааны болон хүний нооцийн удирдлагын мянгуйллыг хангах

2.2.Батлан хамгаалах бодлогыг сурталчлах, хэрэглэгчдэд соёл, мэдээллийн үйлчилгээ, олон нийттэй харьцах.

3.1.Бодлого, төлөвлөгөөний хэрэгжилт, зэвсэглэл, техник, материал хэрэгслийн хангалтын хотелбөрийг зохицуулах

3.2.Батлан хамгаалах төсвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах

4.1.Батлан хамгаалах бодлого, төлөвлөгөө, хотелбер, тесэл, хамтын ажиллагааны гарээ хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ/мониторинг/ хийх, үр дунд нь үнэлгээ өгөх,

4.2.Батлан хамгаалах салбарын мэдээллийн сан, дотоод сүлжээ байгуулах,



3.0. БАТЛАН ХАМГААЛАХ ЯМНЫ УЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦОО, САНАЛ БОЛГОЖ БУЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ. ТЭДГЭЭРИЙН ҮҮРЭГ, ЧИГ ҮҮРЭГ

3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим

Батлан хамгаалах ямны уйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дор дурдсан зарчмыг баримтална:

1. Засгийн газрын уйл ажиллагааны стратегийт уялдсан тухайн ямны стратегийн зорилтыг тусгасан байх зарчим /тухайн ямны уйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь тус ямны уйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх/;

2. Эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хулээхүйц байх зарчим /бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нар нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдлэгээ болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хулээхүйц байх/;

3. Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжийтай байх зарчим /байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын уйл ажиллагааны дур төрх харглахауйц байх, тухайлбал, ямны зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний уйл ажиллагааны стратегийт тусгасан байх/;

4. Бүтцийн хувьд энгийн байх зарчим /тухайн ямны Төрийн нарийн бичгийн даргаас хамгийн доод

нэгжээ хүртэл аль болох цөөн /турваас дээшгүй/ шат дамжуулагатай байх/;

5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим /тухайн ямны үйл ажиллагааны стратеги, бүтцийн зөв зохицай тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, уйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болохоор оновчтой булгэлгээ замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчин болон бусад неецийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг бурдруулсан байх/;

6. Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим /тухайн ямны төрийн захиргааны албан хаагч нь тухайн сайд, Засгийн газар /Танхим/, бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд улс төрийн аливаа нөхөнелрэд автахгүй төвийг сахисан онд мэргэшшийн зөвлөгөө, бүх талын дэмжэлгээ үзүүлэх/;

7. Хангалттай чадавхи, бодитой уйл ажиллагааны зарчим /уйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхиа бүрэн дүүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвар-/тай байх/.

3.2. Уйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон Батлан хамгаалах ямны уйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг ундэслэн тус ямны уйл ажиллагааны бүтцийн дур дурдсан ерөнхий тогтолцооны загварыг санал болгох байна:

### БАТЛАН ХАМГААЛАХ ЯМНЫ УЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦООНЫ ЗАГВАР





## 3.3. Зохион байгуулалтын бүтэц

Батлан хамгаалах яамны үйл ажиллагаа /бизнес-/ны стратегийн болон бүтцийн еренхий тогтолцооны загвараас дор дурдсан зохион байгуулалтын бүтцийн нэгж урган гарч байна:

1. Стратегийн удирдлага, төлөвлөлт эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн нэгдүгээр зорилтын хүрээнд Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах үндсэн үүргийг хүлээж, Зэвсэгт хүчинийг мэргэжлийн чиг баримжаатай болгон хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжаар хангах, цэргийн шинжлэх ухаан, технологийн бодлого, хөтөлбөр, төсөл, улсын дайчилгааны төлөвлөгөө, даалгавар боловсруулах, цэргийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх зэрэг үндсэн чиг үүргийг хүлээн.

Нэгжийн үйл ажиллагаа нь Батлан хамгаалахын сайд, Засгийн газрын Танхимиын үйл ажиллагааны үр нелөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь Ерөнхийлөгч-Зэвсэгт хүчиний Ерөнхий командлагч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Батлан хамгаалахын сайд; Засгийн газрын Танхимиын стратегийн төлөвлөлт,

бодлогын удирдамжаар хангахтай холбогдсон шийдвэр боловсруулан гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдыг шаардлагатай мэдээлэл, ондөр мэргэжлийн, цаг үеэ олсон шуурхай зөвлөгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжиэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Батлан хамгаалахын сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газар /Танхим/ байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, төрийн холбогдох бусад болон хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллага, ард иргэд байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Санхүү, эдийн засгийн яам, Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, аймаг, нийслэлийн Засаг дарга, тэдгээрийн Тамгын газар байна.

Энэ нэгжийн бүтцэд бодлого төлөвлөлтийн, улсын дайчилгааны, гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсүүд ажиллана.

2. Төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн хоёрдугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны



удирдлагын манлайллыг хангах үндсэн үүрэг хүлээж, хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, мэдээлэл, соёл, хэвлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах, захидал, өргөдөл, гомдлыг барагдуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь чадварлаг төрийн албан хаагч бүхий төрийн захиргааны мэргэшсэн цомхон албаны хүчээр яамны тасралтгүй, хэвийн жигд ажиллагааг хангахад чиглэнэ.

Энэ нь Батлан хамгаалахын сайдад болон яамны аппаратад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө дэмжлэгээр хангах, удирдлагын соёл, чадавхийг дээшлүүлэх, тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, төрийн захиргааны албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг нь үнэлж дүгнэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар хэрэгжинэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Батлан хамгаалахын сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны албан хаагчид байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг, цэргийн анги,

байгууллагууд, нутгийн захиргааны байгууллага, төрийн холбогдох бусад байгууллага, ард иргэд, бусад хэрэглэгч байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, боловсрол, сургалтын болон эрдэм шинжилгээний байгууллага байх болно.

Энэ нэгжийн бүтцэд төрийн захиргааны удирдлагын, хүний нөөцийн удирдлагын, хэвлэл, олон нийттэй харилцах хэлтсүүд ажиллана.

3. Батлан хамгаалах салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн гуравдугаар зорилтын хүрээнд батлан хамгаалах салбарын стратегийн болон төсвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндсэн үүрэг хүлээж, агентлаг, аж ахуйн нэгж, байгууллагуудын зэвсэглэл, техник, материал хэрэгслийн хангалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулж, төсвийн тэнцвэрт байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь Засгийн газар, Батлан хамгаалахын сайдын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, батлан хамгаалах бодлого ба зэвсэглэл, техник, материал хэрэгслийн нөөц, төсвийн тэнцвэрт байдлыг хангахад чиглэнэ.



Энэ нь неөцийг оновчтой хуваарилах замаар бодлого хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллагатай түншийн харилцаа тогтоож, тэдний үйл ажиллагааг бодлого, төлевлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн зохион байгуулах, зохицуулах замаар хэрэгжинэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Батлан хамгаалахын сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын холбогдох тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, олон нийт, цэргийн анги, байгууллага, төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн нэгж байх болно. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түвш нь Санхүү, эдийн засгийн яам байна.

Энэ нэгжийн бүтцэд зохицуулалтын, санхүүгийн хэлтсүүд ажиллана.

4. Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн дерөвдүгээр зорилтын хүрээнд батлан хамгаалах салбарын бодлогын хэрэгжилт, төлевлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх үндсэн чиг

үүргийг хүлээж, батлан хамгаалах салбарын мэдээллийн сан, дотоод сүлжээ байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь яамны бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь бодлого, төлевлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үр дагаврыг ажиглах замаар яамны бүтцийн нэгжүүдийн болон бодлого боловсруулах, хэрэгжилтэд оролцож байгаа бүх байгууллага, удирдах, гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэгээр цаг тухайд нь хангах замаар хэрэгжинэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Батлан хамгаалахын сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Засгийн газрын холбогдох тохируулагч агентлаг байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь цэргийн анги, байгууллага, бусад хэрэглэгчид байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцогч гол түвш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, эрдэм шинжилгээний байгууллагууд болон тооцоолох төвүүд байна.

Энэ нэгжийн бүтцэд хяналт-шинжилгээ, үнэлгээний, мэдээллийн сангийн хэлтсүүд ажиллана.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 10 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 166

Улаанбаатар  
хот

### Зэвлэлийн бүрэлдэхүүн батлах, дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын тухай хуульд нэмэлт,  
өөрчлөлт орсонтой холбогдуулан Монгол Улсын  
Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гаалийн тарифын зевлэлийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор шинчлэн баталсугай.

2. "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 1996 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 311 дүгээр тогтооюур баталсан "Монгол Улсын гаалийн тарифын зевлэлийн дүрэм"-д дор дурдсан өөрчлөлт оруулсугай:

а/ 5 дугаар зүйлийг "Зэвлэлийн дэд дарга нь Үйлдвэр, худалдааны дэд сайд, нарийн бичгийн дарга нь Үйлдвэр, худалдааны яамны

худалдааны бодлого, хамтын ажиллагааны газрын дарга байна" гэж өөрчлөн найруулах;

б/ 11 дүгээр зүйлд "Таалийн ерөнхий газрын" гэснийг "Үйлдвэр, худалдааны яамны" гэж өөрчилсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 1996 оны 311 дүгээр тогтооюун 3 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
САЙД**

Н.ЭНХБАЯР

**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ  
САЙД**

Ч.ГАНЗОРИГ

*Засгийн газрын 2000 оны 166 дугаар  
тогтооюун хавсралт*

### МОНГОЛ УЛСЫН ГААЛИЙН ТАРИФЫН ЗЕВЛЭЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга - Санхүү, здийн засгийн сайд

Дэд дарга - Үйлдвэр, худалдааны дэд сайд

Гишиг: -Үндэсний аюулгүй байдлын зевлэлийн нарийн бичгийн дарга /тохиролцсоноор/;  
-Үндэсний татварын ерөнхий газрын дарга;  
-Улсын гаалийн ерөнхий газрын дарга;  
-Батлан хамгаалах яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;  
-Байгаль орчны яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;  
-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газрын дарга;  
-Гадаад хэргийн яамны Эрх зүй,

консулын газрын дарга;  
-Дэд бүтцийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга;  
-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Стратегийн төлөвлөлтийн газрын дарга;  
-Санхүү, здийн засгийн яамны Эдийн засгийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;  
-Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;  
-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Стратегийн төлөвлөлтийн бодлогын газрын дарга;  
-Эрүүл мэндийн яамны Стратегийн төлөвлөлтийн газрын дарга.

Нарийн бичгийн дарга - Үйлдвэр, худалдааны яамны Худалдааны бодлого, хамтын ажиллагааны газрын дарга.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 11 дүгээр  
сарын 6-ны өдөр

Дугаар 168

Улаанбаатар  
хот

### Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсентэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Хамтарсан комиссын Монголын хэсгийн

бүрэлдэхүүнийг шинчлэн батлах тухай" Засгийн газрын 1997 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 64 дүгээр тогтооюун 1 дүгээр зүйлийг дор дурдсаныа өөрчилсүгэй:



Монголын хэсгийн дарга	-Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд	мэргжилтэн.
Гишүүд:	-Үндэсний архивын газрын дарга;	2. "Хамтарсан комиссын Монголын хэсгийн бурзлалтуудын шинчлэн батлах тухай" 1997 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 64 дугаар тогтоолын 3 дугаар зүйлд:
	-Гадаад хэргийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга;	"...ажиллууллахтай" гэсний "ажиллуулах, архивын ажилтын мэргжил дээшлүүлэхтэй" гэж вичлэн найруулсугай.
	-Шинжлэх ухааны Академийн Түүхийн хурzzэлэнгийн захирал;	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР
	-Үндэсний төв архивын захирал;	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ
	-Үндэсний архивын газрын судалгаа-арга зүй, хяналтын хэлтэсийн дарга;	
	-Зэвсэгт хүчиний төв архивын дарга;	
	-Засгийн газрын архивын эрхлэгч;	
	Үйлдвэр, худалдааны яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын ахлах	

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр

Дугаар 169

Улаанбаатар хот

## Аялал жуулчлалын улсын хяналтын дүрэм батлах тухай

Хяналтын дүрэм"-ийн 2.10-ын "ж" заалтыг хүчингүйд тооцусгай.

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

## ДЭД БҮТЦИЙН САЙД

Б.ЖИГЖИД

Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 169 дүгээр тогтоолын хаасрагт

## АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Улсын ерөнхий байцаагч, улсын алхах байцаагч, улсын байцаагч /цаашид "улсын байцаагч" гэх/ хэрэгжүүлнэ.

3. Үйл ажиллагааных нь онцлогийг харгалzan төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлагт ажиллах улсын байцаагчийг Дэд бүтцийн улсын хяналтын албаны дарга, орон нутгийн аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг хянан зохицуулах үүрэг бүхий байгууллагад ажиллах улсын байцаагчийг аймаг, нийслэлийн Засаг дарга, улсын ерөнхий байцаагчтай зөвшүүлснэний үндээн дээр томилж, чөлөөлөх бөгөөд улсын байцаагчийн эрхийг нь аялал, жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

4. Улсын ерөнхий байцаагчийг аялал, жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын

1. Энэхүү дүрмийн зорилго нь Аялал жуулчлалын хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн аялал жуулчлалын салбарт нийтээр дагаж мөрдхөөр тогтоосон стандарт, дүрэм, журмын хэрэгжилтэд тавих захиргааны хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулахад оршино.

2. Аялал жуулчлалын улсын хяналтыг улсын хэмжээнд Засгийн газрын тохиуулагч агентлаг Дэд бүтцийн улсын хяналтын алба, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх мэргжлийн хяналтын алба, орон нутгийн аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг хянан зохицуулах үүрэг бүхий байгууллага болон аялал жуулчлалын хяналтын талаар мэргшсэн



гишүүн томилох, чөлөөлөх бөгөөд ерөнхий байцаагчийн эрх олгох асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

5. Аялал жуулчлалын хяналтын улсын байцаагч нь үйл ажиллагаанд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон энэхүү дурмийг удирдлага болгоно.

Хоёр.Аялал жуулчлалын улсын хяналтын чиглэл

6. Улсын хяналтыг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ:

а/аялал жуулчлалын талаар улсын хэмжээнд мөрдөх байгаа хууль тогтоомж, тэдгээрийг үндэслэн Засгийн газар, төрийн захирагааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

б/аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх болон хөтөч-тайлбарлагчийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох тадгээрийн ангилал, зэрэглэл тогтоох журмын мөрдөлтийг хянаж, зөвшөөрөл эзэмшигч болон түүнийг олготг байгууллагын үүргийн биелэлтийг хангуулах;

в/аялал жуулчлалын байгууллага болон жуулчны үйлчилгээний байгууллага, хөтөч-тайлбарлагчийн үүргийн биелэлтийг хангуулах, жуулчны баазын тухайн ангилал зэрэглэлд тавигдах шаардлага, холбогдох стандартын заалтыг мөрдүүлэх.

Гурав.Аялал жуулчлалын хяналтын улсын байцаагчийн үүрэг, эрх

7. Улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан улсын байцаагчийн нийтлэг үүргээс гадна дор дурдсан үүрэг хүлээнэ:

а/хяналт шалгалтыг энэ дурмийн 6-д заасан чиглэлийн дагуу дангаар болон бусад байгууллага, мэргэжлийн хяналтын улсын байцаагчтай хамтран зохион байгуулж илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

б/аялал жуулчлалын тухай хуулийн 23.2-т заасан үүргийг биелүүлж ажиллах.

8. Улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 27 дугаар зүйл, 21

дүгээр зүйлийн 7, 9-д заасан улсын байцаагчийн нийтлэг эрхээс гадна дор дурдсан эрх эзлэнэ: а/аялал жуулчлалын тухай хуулийн 23.1, 30.1-д заасан эрхийг хэрэгжүүлэх;

б/аялал жуулчлан тухай хуулийн 30.1.1-д заасан үндэслэлээр хуурамч буюу хүчингүй болсон гэрээ, хэлэлцээр тусгай зөвшөөрөл худалдан авах зэргээр аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулсан бол орлогыг хурааж түүнийг аялал жуулчлалын санд төвлөрүүлнэ;

в/аялал жуулчлал эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан, зөвшөөрсөн үйл ажиллагааг зөрчсөн буюу аялал жуулчлалын үйлчилгээг зохих ёсоор бүрэн гүйцэтгэгүй, хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд тухайн байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр буюу бүрмөсөн зогсоо;

г/Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хуулийн 42, Аялал жуулчлалын тухай хуулийн 30 дугаар зүйлийг үндэслэн зөрчил гаргасан буруутай этгээдэд захирагааны шийтгэл ногдуулах;

д/жуулчны үйлчилгээнд бусад салбарын харилцааг зохицуулсан хууль, стандарт, дүрэм, журмаар тогтоосон шаардлагыг хангаагүй зөрчил илэрвэл энэ талаар холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагад тухай бүр мэдгэдэж уг зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах.

#### Дөрөв.Бусад

9. Улсын байцаагчийн албан шаардлагыг байгууллага, аж ахуйн нэгж нь хугацаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор егөх үүргэгтэй.

10. Шалгагдсан байгууллага, аж ахуйн нэгж нь улсын байцаагчийн шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо уг шийдвэр гаргасан өдрөөс 10 хоногийн дотор шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид буюу улсын ерөнхий байцаагчид гаргана.

11. Гомдол гаргах нь торгууль, шийтгэврээр ногдуулсан төлбөр төлөхийг зогсоох үндэслэл болохгүй бөгөөд гомдлыг хүлээн авсан байгууллагын эрх баригч буюу улсын ерөнхий байцаагч нь түүнийг авсан өдрөөс 30 хоногт багтаан хянан шийдвэрлэнэ.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 11 дүгээр  
сарын 8-ны өдөр

Дугаар 170

Улаанбаатар  
хотҮндэсний зөвлөлийн бүрэлдэхүүний  
тухайМонгол Улсын Засгийн газраас ТОГТООХ  
ны:1. "Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний  
хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,

Дарга

-Хүнс, хөдөө аж ахуйн сайд

Гишүүд:

- Үйлдвэр, худалдааны дэд сайд;
- Санхүү, здийн засгийн дэд сайд;
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд;
- Эрүүл мэндийн дэд сайд;
- Гадаад хэргийн дэд сайд;
- Монголын радио, талевизийн Хэрэг зэрхлэх газрын дарга;

- Үндэсний статистикийн газрын дэд дарга /тохиролцсоноор/;
- Хүнс, хөдөө аж ахуйн яамны Стратегийн төвлөлт, бодлогын газрын дарга;
- Албан бус боловсролын төвийн захирал;

- Монголын үйлдвэр, үйлчилгээний хорооны холбооны ерөнхийлөгч /тохиролцсоноор/;
- Монголын хөдөө аж ахуйн хорооолгын үндэсний холбооны ерөнхийлөгч /тохиролцсоноор/;
- Монголын үйлдвэрлэлийн хороооллын төв холбооны ерөнхийлөгч /тохиролцсоноор/;

- Монголын эд хэрэглэгчдийн хороооплын төв холбооны ерөнхийлөгч /тохиролцсоноор/;
- Монголын ардын аж ахуйтын хорооодын холбооны ерөнхийлөгч /тохиролцсоноор/;

- Монголын хадгаламж, зээлийн хорооодын холбооны ерөнхийлөгч /тохиролцсоноор/.

Нарийн бичгийн  
дарга

-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан  
"Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 1998 оны 8  
дугаар сарын 12-ны өдрийн 145 дугаар тогтоолын 1  
дэх заалтаас "... уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх  
Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар  
хавсралтын... " болон "... тус тус..." гэснийг хүчингүй

болжонд тооцусгай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ

САЙД

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН

САЙД

Н.ЭНХБАЯР

Д.НАСАНЖАРГАЛ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөлУлаанбаатар-12  
Төрийн ордон329612  
Индекс 14003Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

329487







# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 50 (187)

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- Ерөнхийлөгчийн хоригийн тухай
- Засгийн газрын бонд гаргахыг зөвшөөрөх тухай

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- Гаалийн тайлварын хувь хэмжээг өөрчлөх тухай

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот  
2000 он